



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙДЫН ЗАХИРАМЖ

2024 оны 05 сарын 22 өдөр

Дугаар 76

Улаанбаатар хот

Ажлын хэсэг байгуулах тухай

1. “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлттэй холбогдуулан авах арга хэмжээний тухай” Улсын Их Хурлын 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрийн 44 дүгээр тогтоолын 3, “Төрийн байгууллагуудыг бүсчлэн байршуулах тухай” Улсын Их Хурлын 2024 оны 01 дүгээр сарын 17-ны өдрийн 12 дугаар тогтоолын 1.1, 1.3, “Засгийн газарт чиглэл өгөх тухай” Улсын Их Хурлын 2024 оны 05 дугаар сарын 02-ны өдрийн 40 дүгээр тогтоолд заасан арга хэмжээний хүрээнд Засгийн газрын байгууллагуудын нэгдсэн байрны цогцолборын техник, эдийн засгийн үндэслэл, зураг төслийг холбогдох дэд бүтэц, Их тэнгэрийн болон Номтын амны ерөнхий төлөвлөлттэй нягт уялдуулан, цогц төслийг төлөвлөн зохион байгуулах ажлыг нэгдсэн удирдлага, мэргэжил, арга зүй, зохион байгуулалтаар хангах үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай:

- Дарга: -Б.Дэлгэрсайхан-Монгол Улсын сайд, Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны дарга
- Гишүүд: -Ч.Хүрэлбаатар-Монгол Улсын Шадар сайд бөгөөд Эдийн засаг, хөгжлийн сайд;
- Д.Амарбаясгалан-Монгол Улсын сайд, Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дарга;
- Б.Жавхлан-Сангийн сайд;
- Б.Энхбаяр-Хууль зүй, дотоод хэргийн сайд;
- Б.Бат-Эрдэнэ-Байгаль орчин, аялал жуулчлалын сайд;
- Ц.Даваасүрэн-Барилга, хот байгуулалтын сайд;
- С.Бямбацогт-Зам, тээврийн хөгжлийн сайд;
- Ч.Номин-Соёлын сайд;
- Б.Чойжилсүрэн-Эрчим хүчний сайд;
- Х.Нямбаатар-Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагч;

-Б.Энх-Амгалан-Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дэд дарга (зөвшилцсөнөөр);

-У.Бямбасүрэн-Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын дэд дарга;

-П.Одонбаатар-Тагнуулын ерөнхий газрын дарга;

-Л.Алтангэрэл-Төрийн тусгай хамгаалалтын газрын даргын үүрэг гүйцэтгэгч.

Нарийн бичгийн дарга:

-П.Сайнзориг-Нийслэлийн Засаг даргын Эдийн засаг, дэд бүтцийн асуудал хариуцсан нэгдүгээр орлогч;

-Д.Баярдорж-Нийслэл Улаанбаатар хотын авто замын түгжрэлийг бууруулах Үндэсний хорооны Ажлын албаны дарга.

2.Ажлын хэсгийн үйл ажиллагааны явц байдлыг тухай бүр Засгийн газрын хуралдаанд танилцуулж ажиллахыг Ажлын хэсэг (Б.Дэлгэрсайхан)-т үүрэг болгосугай.



МОНГОЛ УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД

Л.ОЮУН-ЭРДЭНЭ